

## **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:**

### **Доктор Г.Цогзолмаа:**

Энэ илтгэлээр хятад хэлнээс монгол хэл рүү орчуулсан бүтээлүүдийн тухай нэлээд тодорхой танилцууллаа. Хоёр орны утга зохиолын орчуулгын бүтээлүүдийг орчуулахдаа хятад-монгол, монгол-хятад гэсэн хоёр талын орчуулгыг илүү анхаарч үзээсэй гэж хүсдэг. Шинэ Хятад улс байгуулагдсаны дараа анх 1951-1952 онд Шанхайн гадаад хэлний хэвлэх үйлдвэрээс Ц.Дамдинсүрэнгийн Монголын нууц товчоог албан ёсоор хоёр жил дараалан хятад хэл дээр гаргаж байсан. Монголын уран зохиол тэр дундаа «Монголын нууц товчоо»-г дэлхийн соёлын үнэт өв болохын хувьд онцлон авч үзсэн нь их сайшаалтай санагддаг. Учир нь шинэ Хятад улс байгуулагдсаны дараа олон улсын бүтээлүүдийг олон өнцгөөс харах зорилгоор хэвлэн гаргадаг байжээ. Түүний дараагаар 1955-1960 оны хооронд Монголын зохиолуудыг маш олноор нь орчуулан гаргасан. Үүнд Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Д.Сэнгээ, Ч.Лодойдамба нарын 20 гаруй зохиол орсон байдаг. Энэ үеийн хэл шинжээчид, зохиолчид, орчуулагчдаас Цин Найсун гээд орчуулагч илүү үнэтэй хувь нэмэр оруулсан гэж хэлж болно. 1970, 1980-аад он хүртэл Монголын утга зохиолын бүтээлүүдийг орчуулсан нь маш бага. 10-20 жилд энэ ажил зогссон нь харагддаг. Харин 1980-аад оны дунд үеэс ӨМӨЗО-ны Монгол судлаачдын бүтээлүүд гарч ирснээр Ч.Лодойдамбын «Тунгалаг тамир» зэрэг бусад зохиолууд, 1990-ээд оноос Б.Лхагвасүрэн гуайн орчуулгын зохиолууд, Г.Аким багшийн «Тэнгэрийн нохой» гэх мэт олон бүтээлүүд орчуулагдан гарсан байдаг. Саяын илтгэлд дурдсан бүтээлүүд дээр нэмээд манай судлаачид тэр дундаа хэл шинжлэл, утга зохиолын салбараас гадна түүхийн салбарын залуу эрдэмтэд маш олон судалгааг хийж байна. Жишээ нь, МУИС-ийн багш, доктор Б.Ундрах, МУБИС-ийн багш, доктор Д.Идэр зэрэг сүүлийн үеийн судлаачид олон бүтээл орчуулж, хоёр орны хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулж байгаа гэдгийг хэлэхэд таатай байна.

### **Доктор Ш.Эгшиг:**

Сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн Лю профессор баярлалаа. 1952 оны хэлэлцээртэй холбоотойгоор орчуулгын ажлын талаар ярих нь зөв болов уу гэж бодлоо. Манай МУИС-ийн багш нар 1949-1969 оны хооронд хятад хэлнээс монгол хэл рүү орчуулсан орчуулгын зохиолуудыг бүртгэсэн билээ. Бүртгэх явцад 1949-1952 он хүртэл ямар нэгэн орчуулгын уран зохиол олдоогүй. Харин 1952-1962 оны хоорондох 10 жилийн хугацаанд орчуулсан өгүүллэгүүдийг 2019 онд тэр байсан чигээр нь дахин эмхэтгэж хэвлэсэн юм. Энэ 10 жилийн хугацаа уран зохиолын орчуулгын хамгийн оргил үе байсан гэдгийг хэлмээр байна. 1952 оны хэлэлцээр байгуулагдах

жил, БНХАУ байгуулагдсаны 3 жилийн ойн ёслолын арга хэмжээнд БНМАУ-ын зочид төлөөлөгчид оролцох, ойн баярын үеэр хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах ажилд хоёр тал ихээхэн хүчин чармайлт гарган, ач холбогдол өгч идэвхтэй бэлтгэж байсан байдаг. Ингээд ойн арга хэмжээний үеэр хэлэлцээрийг үзэглэж, мөн үүнд зориулсан соёлын өдрүүдийг анх зохион байгуулсан байдаг юм. Монголын Зохиолчдын Эвлэлээс Хятадын шилдэг уран зохиолоос орчуулах ажлыг 1952 оны соёлын өдрүүдэд зориулж эхлүүлэхэд Бат гэдэг орчуулагч Лү Шюнийн зохиолуудаас орчуулсан нь 1951-1952 оноос эхлэлтэй байдаг. Ингээд бид тухайн үеийн хятад хэлнээс орчуулсан зохиолуудыг цуглуулаад үзэхэд богино өгүүллэгүүдийг сонгон орчуулсан нь харагддаг юм билээ. Орчуулгуудын дотор тууж, роман, яруу найргийн зохиол ч мөн байсан. Зөвхөн богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиол болох өгүүллэгүүдийг эмхэтгэхэд Хятадын том зохиолчийн бүтээл, жишээ нь, Гуо Моруогийн «Шанхайн өглөө», Малчинхүүгийн зохиол «Хорчины тал газрын хүмүүс», Ма Жягийн «Гандашгүй цэцэг», хамгийн гол нь Лү Шюний алдарт богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиолууд нь голлож байв. Энэ арван жилийн орчуулгын оргил үеийн дараа хожим хувьсгалт зохиолчдын зохиолыг голдуу монгол хэл рүү орчуулсан. Монголын нэртэй зохиолчдын (Д.Нацагдорж, С.Эрдэнэ, Д.Намдаг, Д.Сэнгээ, Ч.Лодойдамба, С.Тарва) зохиолыг мөн хятад хэл рүү орчуулсан байдаг. Энэхүү Хятадын богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгыг дахин эмхэтгэх ажлын хүрээнд 1952-1962 оны хоорондох 10 жилд Хятадын соёлыг Монгол оронд гайхамшигтайгаар түгээж байсан ба түгээх арга зам нь орчуулгын ажил байсныг хүлээн зөвшөөрч байсныг тодотгож хэлье. 1952 оноос хойших үе Монгол-Хятадын эдийн засаг, соёлын харилцааны оргил үе байсан гэдэг нь эдгээр орчуулгын материалаас харагдаж байна. Нөгөө талаар өнөө цагт монгол-хятад, хятад-монгол орчуулгын санд түүхийн болон нийтлэлийн орчуулга нэлээд олон тоотой гарч байна. Үүний зэрэгцээ уран зохиолын орчуулгын хувьд хоёр талын орчуулгын байдал харьцангуй тэнцүү биш байгааг хэлэх нь зүйтэй болов уу. 1949 оноос хойш хятад хэлнээс монгол хэлд орчуулсан орчуулгын тоо монголоос хятад руу орчуулсан орчуулгын тоотой харьцуулахад мөн л харилцан адил тэнцүү бус явж ирсэн байдаг. Сая илтгэлд дурдсанаар 2022 онд хоёр орны Соёлын яам хооронд гэрээ байгуулж, хоёр хэлний орчуулгын ажлыг 50/50 хувиар тэнцүүлж байгаад талархаж байна. Орчуулга хийх гэдэг нь нөр их хичээл зүтгэл цаг хугацаа орсон, хүчир ажил байдаг гэдгийг хүмүүс өөрсдөө орчуулга хийж үзээд мэдэрдэг. Энэ хуралд орчуулгын салбарын судлаачийн илтгэлийг оруулсан зохион байгуулагчдад баярлалаа.